



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, 18,190,000.00 (арван найман сая нэг зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг худалдах хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн захирал Б.Очирбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Үндсэн хөрөнгийг сэлбэгээр худалдсанаас олох орлогыг байгууллагад төвлөрүүлэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001501



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн
СХ дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ
1	Мицубиши Делика, УБО 01-74, суудлын, арал: Р35W-0900854	1999/2008	437,000	18,190,000.00	18,190,000.00	-	100,000.00
				18,190,000.00			100,000.00
Нийт дүн				(арван найман сая нэг зуун ерэн мянган)			(нэг зуун мянган)